

“ЭРҮҮЛ ШҮД” 2024-2027 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Орхон аймаг

2025.12.20

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэт гэлийн хувь	Төсөв		Биелэлт, үр дүн	Үнэл гээ
			Нийт төлөвлөсөн төсөв (сая)	Зарцуулсан төсөв, эх үүсвэр (сая)		
1.Амны хөндийн эрүүл мэндийн бодлого, эрх зүйн орчныг сайжруулах						
1.1	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих боловсрол олгох тогтвортой санхүүжилтын эх үүсгэвэр бүрдүүлэнэ	100%	8.4 сая	ОНТ	Аймгийн ИТХ-аар батлагдсан “Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд амны хөндийн эрүүл мэндийг дэмжих,хамгаалах чиглэлээр орон нутгийн төсөвт 8.4 сая төгрөгийг тусган батлуулж, Эрүүл шүд арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан.	100
1.2	Хүүхдийн шүд, амны хөндийн үзлэг, оношилгоо эмчилгээний бүртгэл мэдээллийг салбар хооронд солилцох эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн мэдээллийн санг байгуулах	100%	-	-	Сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх илрүүлэг үзлэгт 22 сургуулийн 2576 суралцагчаас 2450 буюу 95,1 хувь нь хамрагдан, aimag.eruulhuuhed.mn программд шивэлт хийгдэж, бүртгэл мэдээлийн сан үүсгэсэн. Нийт 1773 буюу 68,8 хувьд өвчлөлийн сэжигтэй тохиолдол илэрч, 720 буюу 28,1 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн байна.Үзлэгээр силант түрхүүлсэн 1549 /82,4%/,фторт түрхлэг түрхүүлсэн 2405 /99%/, шүдний цооролтой 1991 /81,8%/,шүдний гажигтай 673 /27,6%/, шүдээ бүрэн угаадаггүй 1974 /81.1%/ хүүхэд байна.	100
2.Амны хөндийн эрүүл мэндийн бодлого, эрх зүйн орчныг сайжруулах						
2.1	Амны хөндийн эмгэг үүсгэгч эрсдэл хүчин зүйлийг бууруулах санаачилгыг дэмжих, иргэдэд чиглэсэн аян зохион байгуулах	85%	-	-	Амны хөндийн эмгэг үүсгэгч эрсдэл хүчин зүйлийг бууруулах чиглэлээр 6 үйл ажиллагааг төлөвлөж,хэрэгжилт 85,0%-тай хэрэгжсэн байна. 24/3 аяны хүрээнд зохион байгуулсан сургалтад өсвөр үе, оюутан залуус зэрэг 12766 хүнийг хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. Улаан загалмайн хороотой хамтран “Эрүүл эмэгтэй-Эрсдэлгүй гэр бүл” уриатайгаар зохион байгуулсан арга хэмжээнд амны хөндийн эрүүл мэнд сургалтыг 450 эмэгтэйг хамруулсан. “Өсвөр үеийнхнийг сонсьё ойлгоё” өдөрлөгт хамрагдсан 120 хүүхдэд амны хөндийн эрүүл мэнд сургалт зохион байгуулж, тэдний мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн.”Эрүүл эхээс эрүүл хүүхэд” сургалтад 120 төрөх насны болон төрсөн ээжүүдэд “Дэлхийн эрүүл мэндийн өдөр” хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, 100 хүнд зөвлөгөө мэдээлэл хүргэж, шүдээ хэн сайн угаах вэ? уралдаан зохион байгуулсан.Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн 21 албан хаагчдад, малчин	70

					иргэд 30, Баян-Өндөр сумын 29 багийн нийгмийн ажилтнууд, 39 цэцэрлэгийн 8907 эцэг эхэд, 24 сургуулийн 2432 эцэг эхчүүдийг хамруулан зохион байгууллаа.	
2.2	Хүүхдийн шүдний урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, шүдийг эрдэсжүүлэх аяныг зохион байгуулана.	50%	-	-	Орхон аймгийн хэмжээнд 24/3 аяныг өрнүүлж, нийт 12407 хүүхдэд шүдний урьдчилан сэргийлэх үзлэг хийлээ.Тус үзлэгээр хүрээнд 24 сургуулийн 2432 хүүхдэд, 32 цэцэрлэгийн 8907 хүүхдэд үзлэг хийж, 2714 хүүхдэд эрдэсжүүлэлт хийлээ.	70
2.3	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг, ЕБС-ийг хөгжүүлэх санаачилгыг өрнүүлэх	100%	8.4	5.4	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг боловсролын байгууллагын 56 нэгжид зохион байгуулж, БГ-тай хамтран ажилласан. Сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад “Зөвийг дадал болгоё” аяныг өрнүүлж, эцэг эх асран хамгаалагч хүүхдийнхээ хамт оролцох боломжийг бүрдүүлсэн.Шүд угаах уралдааныг БГ, Шүдний мэргэжилтнүүдийн холбоотой хамтран амжилттай зохион байгуулсан. Уг арга хэмжээг улсын хэмжээнд анх удаа зохион байгуулж, 248 хүүхэд 248 эцэг эх асран хамгаалагч 64 багшийг оролцуулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна.Тайлант хугацаанд Ерөнхий боловсролын сургуулиудад 7 хоногт 1 удаа ангидаа шүд угаах аяныг өрнүүлж, 24 сургуулийн 25122 хүүхдийг хамруулсан.	100
2.4	Цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын орчинд шүд угаах орчныг үе шаттай бүрдүүлэх, сургалтын байгууллагын орчинд шүд угаах цагийн зохицуулалтыг хийж, сурагчдад шүд угаах зан үйлийг төлөвшүүлэх	90%	-	-	Аймгийн Хүүхдийн байгууллагуудад эрүүл ахуйн шаардлага хангасан шүд угаах хэсэгтэй эсэхэд ЭМГ-аас 2 удаа үнэлгээ хийж ,холбогдох зөвлөмжөөр хангаж ажилласан.Тус үнэлгээгээр СӨБ-ийн байгууллагын 95,0% шаардлага хангасан, ЕБС-иудад шүд угаах орчинг бүрдүүлсэн эсэхийг үнэлэхэд 2 сургууль шүд угаах булантай, 3 сургуулийн шүд угаах булан бэлтгэл ажилдаа байгаа, 6 сургууль шүд угаах цагийг тогтмолжуулж ажиллаж байна. Орхон аймагт үйл ажиллагаа явууладаг 39 цэцэрлэг, 24 сургууль,политехникийн 1, их дээд сургууль 1 нийт 65 байгууллагын эмч эрхлэгч, эрүүл мэндийн багш, анги удирдсан багш зэрэг нийт 1628,эцэг эх 1076, хүүхэд 4799 хүнд шүд угаах онол дадлага хосолсон сургалт зохион байгуулж, нийт 20 удаагийн сургалтад хамрагдаж, мэдлэг хандлагаа нэмэгдүүлсэн байна.	70
2.5	Ажлын байранд суурилсан амны хөндийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, “Шүд угаах цаг”-ийг хэрэгжүүлэх	100%	-	-	Ажлын байранд суурилсан амны хөндийн эрүүл мэндийг дэмжих 2 үйл ажиллагаа зохион байгуулж 40 байгууллагын 1649 хүнийг хамрууллаа. Үүнд: Орхон аймгийн үйлдвэрчний хороотой хамтран хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд “Амны үнэргүй ажлын байр “аяныг зохион байгуулан 16 байгууллагын 1579 хүнд шүд угаах онол дадлага хосолсон сургалт, 24/3 аяны хүрээнд төрийн 24 байгууллагын 70 хүнд шүд угаах онол дадлага хосолсон сургалтыг хийлээ.	100

2.6	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих олон нийтэд түшиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	80%	23.3	23.3	Тайлант хугацаанд “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газартай хамтран тус байгууллагын 23,3 сая төгрөгийн санхүүжилтээр Эрдэнэт үйлдвэрийн цагаан тоосны бүсэд амьдардаг иргэдийн эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан. Энэ хүрээнд Цагаан тоосны нөлөөллийн бүсэд амьдарч байгаа 1500 хүний амны хөндийн эрүүл мэндийг үнэлж, шүд угаах аргачлалыг таниулах сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. Аймгийн ЗДТГ, ИТХ, Мишээл хүүхэд сан ТББ, Эрүүл мэндийн газар, Шүд холбоотой хамтран 2025 оны 10 дугаар сараас 08-наас 10 хүртэл нийт 85 сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч, сум, өрхийн эрүүл мэндийн төв эмч, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, шүдний эмч, эрүүл ахуйч нарыг хамруулж, сургагч багш бэлдэж, багш нар нийт 22 удаагийн шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөв дадал хэвшүүлж сургах, шүд угаах, шүдний цооролтын талаар мэдлэг мэдээлэл олгох зорилгоор сургалт, хийгдэж багш ажилчид 426, эцэг эх 1151, хүүхэд 4962 хамрагдсан сургалт зохион байгуулсан байна.	100
2.7	Амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянах шүд цоорох өвчний хүндрэлээс сэргийлэх мэдлэг дадал олгох сургалт сурталчилгаа явуулах	80%	-	-	Орхон аймгийн Эрүүл мэндийн газраас 2025 оны 4 сарыг Эрүүл мэндийг дэмжих сар болгон зарлаж нийт 19 ажил төлөвлөснөөс амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр мэдлэг олгох, сургалт сурталчилгаа хийх чиглэлээр 4 ажлыг төлөвлөн амжилттай зохион байгуулсан. Тухайлбал 24/3 аяны хүрээнд сургалт зохион байгуулж 1120 хүнийг хамруулсан. Үүнд: Улаан загалмайн хороотой хамтран “Эрүүл эмэгтэй-Эрсдэлгүй гэр бүл” уриатайгаар зохион байгуулсан арга хэмжээнд амны хөндийн эрүүл мэнд сургалтыг 450 эмэгтэйд хийлээ. Мөн “Өсвөр үеийнхнийг сонсьё ойлгоё” өдөрт хамрагдсан 120 хүүхдэд амны хөндийн эрүүл мэнд сургалт зохион байгуулсан. Эрүүл эхээс эрүүл хүүхэд сургалтад 120 төрөх насны болон төрсөн ээжүүдэд .Мөн “Дэлхийн эрүүл мэндийн өдөр” хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 100 хүнд зөвлөгөө мэдээлэл хүргэж, шүдээ хэн сайн угаах вэ? уралдаан зохион байгуулж, тэдний мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна.	80
3.Нүүр ам судлалын салбарын хүний нөөцийг дэмжих, чадавхыг бэхжүүлэх						
3.1	Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах	50%	1.4 сая	1.4 сая	Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг улсын 2, хувийн хэвшлийн 15 эмнэлэг нийт 17 байгууллагад 108 эмч эмнэлэгийн мэргэжилтэн ажиллаж байна. Магистер зэрэгтэй 7 , ахлах 4, тэргүүлэх 1,зөвлөх зэрэгтэй 1 хүн ажиллаж байна. Тайлант хугацаант 2 сургалт зохион байгуулж, 75 шүдний эмчийг хамруулсан.Үүнд: Халдварын сэргийлэлт хяналтын сургалтад нийт 65 хүн, яаралтай тусламжийн сургалтад 15 хүн хамрагдсан	70
3.2	Нүүр ам судлалын салбарын эмч, мэргэжилтнүүдийг нийгмийн эрүүл мэнд, менежмент, манлайллын чиглэлээр	100 100%	12,7 сая -	12,7 сая -	Эрүүл мэндийн газраас 2023-2025 онд “Зөвийг дадал болгоё” нийгмийн эрүүл мэндийн төслийг 38.3 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн. Энэхүү үйл ажиллагаанд шүдний 11 клиникүүдтэй хамтран 21412 ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүд, эцэг эх, асран хамгаалагч, багш, эмч нарыг хамруулан нийгмийн эрүүл мэндийг дэмжих хамгаалах чиглэлд Орхон аймгийн шүдний мэргэжилтний холбоо манлайлан	100

	бэлтгэх				оролцсон байна.	
3.3	Сувилагч, эрүүл ахуйч, техникч, олон нийтийн эрүүл мэндийн ажилчдад зориулсан амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, чадавхжуулах сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	70	-	-	Эрдэнэтдент шүдний эмнэлэг АШУҮИС-ийн Дархан салбар сургуультай хамтран шүдний эрүүл ахуйчийн сургалтыг хамтран зохион байгуулж, 12 техникчийг хамруулан чадвахжуулсан байна. Монголын сувилахуйн мэргэжилтний холбоо, Медклин компаны хамтарсан халдварын сэргийлэлт хийх материалыг танилцуулах сургалтад 17 ариутгалын сувилагчийг хамруулан чадвахжуулсан байна.	70
3.4	Нүүр амны тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах	50%	-	-	Тайлант хугацаанд Монголын шүдний ерөнхий мэргэжилтний холбоотой хамтран "Шүдний эмнэлэгийн халдвараас сэргийлэх орчин үеийн чиг хандлага" 10 цагийн онол дадлага хосолсон сургалтыг орон нутагт зохион байгуулж, 17 эмнэлгийн 61 эмч, сувилагч эмнэлэгийн мэргэжилтнийг сургаж гэрчилгээ олгосон.	100
4 Анхан шатны тусламж үйлчилгээнд нүүр амны тусламж үйлчилгээг нэвтрүүлэх						
4.1	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад 0-3 насны хүүхдийн шүд болон эрүүл мэндийг хамгаалах талаар эцэг эх, асран хамгаалагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадваржуулах ажлыг өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан гэр бүлд суурилсан эрүүл мэндийн боловсролын үйлчилгээг хүргэнэ	60%	-	-	Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг сум, өрхийн эрүүл мэндийн 8 төвийн 9 эх баригч нар жирэмсэн ээжийн сургалтыг сар бүр зохион байгуулж байгаа ба энэхүү сургалтын хөтөлбөрт 0-3 насны хүүхдийн шүд болон эрүүл мэндийг хамгаалах талаар эцэг эх, асран хамгаалагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг оруулсан. Тус жирэмсэн ээжийн сургалтын хөтөлбөрт ээжийн амны хөндийн эрүүл мэнд шүд угаах арга, жирэмсэн үеийн эрүүл зөв хооллолт, хүүхдийн шүд хэзээ бүрэлддэг вэ? Нярай хүүхдийн амны арчилгаа, 1-2 настай хүүхдийн шүд угаах арга, 3-4 настай хүүхдийн шүдний арчилгаа онцлогийг тусгасан сэдвээр 45 удаагийн сургалт зохион байгуулж, 1050 жирэмсэн ээжүүдийг хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна.	100
5. Нүүр амны тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх						
5.1	Шүд амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг	100%	-	-	Орхон аймагт 13 шүдний эмнэлэг тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Эрүүл мэндийн газраас төлөвлөгөөт дэмжлэгт хяналтыг 2 удаа хийж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Тус клиникүүдэд хийсэн үнэлгээгээр халдварын сэргийлэлт, хяналтын багийг тушаалаар томилж батлагаажуулан чиг үүргийг тодорхойлж үүрэгжүүлсэн 100%, ариутгалын 6-р зэргийн тестийг 100% ашиглаж хэвшсэн, цус уургийн үлдэгдэл тодорхойлох тестийг 92%, Bowie dick тестийг 92%,	100

	хяналт хийнэ				биологийн индикаторыг 85% ашиглаж байгаа бөгөөд ажилчдаа 100% шинжилгээнд хамруулж ажиллаж байна. 2025 оны 12 сараас эхлэн биологийн индикаторыг нэгдсэн байдлаар жолоочтой гэрээ хийж, хот руу шинжилгээнд явуулж эхлээд байна. Ариун материалын шинжилгээг тогтмол Орхон аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн лабораторит шинжлүүлж хэвшсэн. СХЗХ лабораторийн итгэмжлэлийн хүрээнд ам зайлан усны шинжилгээ байхгүйн улмаас шинжилгээнд авахгүй байна.Өдөр тутмын цэвэрлэгээ, халдваргүйтгэл, ариутгалын бодис материалын хангалтыг доод тал нь 1 сарын нөөцтэйгөөр бэлдэж хэвшсэн.Шүдний мэргэжилтний холбооноос 2025 онд Халдварын сэргийлэлт, хяналтын мэдлэг дээшлүүлэх, бататгах зорилгоор 2 дахь жилдээ шүдний клиникүүдийн дунд АСТ тэмцээн зохион байгуулж, шүдний эмч, техникч, ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлсэн байна.	
5.2	Шүд амны хөндийн тусламж үйлчилгээг үзүүлэх явуулын багийг төр хувийн хэвшлийн эмнэлгүүдэд түшиглэн байгуулах, алслагдсан баг суманд ажиллуулах	70%	-	-	Орхон аймгийн Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн шүдний кабинетыг хүний нөөцөөр ханган ажиллах гэрээг байгуулж, Хаш шүдний клиник ажиллаж байна. Жаргалант сумын 1 ангийн 36 хүүхдэд явуулын багийг ажиллуулж урьдчилан сэргийлэх үзлэг эрдэсжүүлэлтийг хийж ажиллаа.	70
Үнэлгээний хувь 87,5% /Тодорхой үр дүнд хүрсэн/						

ТАЙЛАН НЭГТГЭСЭН : ХТХАБМ

Т.ЦЭЦЭГСҮРЭН

ХЯНАСАН:ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ

“ЭРҮҮЛ ШҮД” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2024-2027/-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2022 он	Хүрэх түвшин 2025 он /улс/	Хүрсэн түвшин 2025 Орхон аймаг	Мэдээлэлийн эх үүсвэр
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт					
1	Шүдний урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоонд тухайн жилд хамрагдсан хүүхдийн тоо	200,000	150,000	2554	ЭМДЕГ
2	Шүдний урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээнд хамрагдсан, нэмэлт эрдэсжүүлэлт хийлгэсэн хүүхдийн тоо	-	600	2714	ЭМДЕГ
3	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд өдрийн цайны дараа "Шүд угаах цагийг хэрэгжүүлдэг болсон боловсролын байгууллагуудын эзлэх хувь	2	40	95%	БШУЯ
4	Дижитал технологи ашиглан амны хөндийн эмгэгийг эрт илрүүлэх, оношлох, эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо	-	200,000	1000	НЭМГ, АЭМГ
5	Нүүр амны тусламж, үйлчилгээний халдвар хамгаалал, чанар аюулгүй байдлын чиглэлээр чадавхжуулсан эмч, мэргэжилтнүүдийн тоо	50	400	78	ЭМЯ
6	Амны хөндийг эрүүлжүүлсэн 5-12 насны хүүхдийн тоо	5000	30,000	720	ЭМДЕГ
7	6 настай хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалтын эзлэх хувь	87,6	86,4	86.2	НАСМСҮЗ
8	6 настай хүүхдийн дунд шүд цоорох өвчний ЦЛ (цоорсон, ломбодсон шүдний тоо	6,2	5,5	5.8	НАСМСҮЗ
9	12 настай хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалтын эзлэх хувь	77	75	7	НАСМСҮЗ
10	12 настай хүүхдийн дунд шүд цоорох 10. өвчний ЦЛ (цоорсон, ломбодсон шүдний тоо)	2,2	2,0	2.1	НАСМСҮЗ
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт					
11	Боловсролын байгууллагын шинээр байгуулсан шүд угаах цэгийн тоо	2	114	9	БШУЯ
12	‘Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих нь’сэдвээр сургалтад хамрагдсан цэцэрлэг, ЕБС-ийн багш нарын тоо	0	400	1628	БШУЯ
13	Нийгмийн эрүүл мэндийн, менежмент, манлайллын чиглэлээр бэлтгэгдсэн Нүүр ам судлалын салбарын эмч, мэргэжилтнүүдийн тоо	1	15	15	ЭМЯ
14	Нүүр амны тусламж, үйлчилгээг анхан шатанд хүргэж эхэлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	0	150	1	НЭМГ АЭМГ

15	Дижитал технологийг нүүр амны тусламж, үйлчилгээнд нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	0	150	4	НЭМГ АЭМГ
----	---	---	-----	---	--------------